# ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
# ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 05 өдөр    Дугаар А/219    Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яам, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран зохион байгуулах "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага" сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлагсугай.

2. Хоёрдугаар хавсралтад дурдагдсан зардлыг төсвийн Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Чанар, магадлан итгэмжлэлийн алба /Х.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ    Б.НАРАНТУЯА

Эрүүл мэндийн хөгжлийн төвий ерөнхий
захирлын 2017 оны ...12....сарын ..05..өдрийн
A/219 дугаар тушаалын 1 дугаар хавсралт

## НЭГ. “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЛИЙН УДИРДЛАГА” СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Боловсруулсан: П.Мидриймаа /ЧМИА-ны мэргэжилтэн/

Хянасан: Х.Ганцэцэг /ЧМИА-ны дарга/

Сургалт зохион байгуулах байгууллага: Эрүүл мэндийн хөгжлийн төв

Сургалт хариуцсан мэргэжилтний нэр, холбогдох утас: П.Мидриймаа 99252574

Сургалт явагдах огноо: 2017 оны 4 дүгээр улиралд

Сургалтын үргэлжлэх хугацаа: 2 хоног

Сургалт хийх байршил: Улаанбаатар хотод зохион байгуулна.

Сургалтын агуулгын багтаамж: Нийт 16 цаг: /Лекц ... цаг, Дадлага: ....цаг/ .... кредит

Нэг удаагийн сургалтын анги дүүргэлт: 50-60

Сургалтын төлбөр: ..........төг Нийт-1удаагийн сургалт УБ хотод -1 удаа/

Сургалтын төрөл: Танхимын, ажлын байрны, зайн, эрдэм шинжилгээний хурал

С№ .............

ЗӨВШӨӨРСӨН: З.НАРАНБААТАР /ЭМАХА-ны дарга/

он сар өдөр

ХӨТӨЛБӨР ХЯНАСАН: О. Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/

# “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА” СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

## ҮНДЭСЛЭЛ:

Эрүүл мэндийн байгуулагуудад 2000 оноос “Магадлан итгэмжлэл” олгож чанарын хөтөлбөр төлөвлөгөөтэй болсон зэрэг нь чанарын удирдлагын эхлэл болсон бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр манай бүх шатлалын эмнэлгүүд чармайлт гарган ажиллаж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн байгууллагуудад чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах, зөвлөн туслах, магадлан итгэмжлэлийн бэлтгэл хангуулах чиглэлээр сургалт зохион байгуулах зэрэг чиг үүргийнхээ хүрээнд эрүүл мэндийн салбарын хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, чанарын алба болон багийн ахлагч, гишүүд, чанарын менежер, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах шаардлагатай байна.

## СУРГАЛТЫН ЗОРИЛГО:

Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын чиглэлээр чадавхжуулахад оршино.

## СУРГАЛТЫН ЗОРИЛТ:

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага, асуудлын дүн шинжилгээний арга хэрэгслүүдийг хэрхэн практикт ашиглах ур чадварыг эзэмшүүлэх

2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эмнэлгийн алдаа, эрсдлийн удирдлага, эрсдлийг тодорхойлох, үнэлэх мэдлэг, ур чадварыг сайжруулах

## ХАМРАГДАХ ХҮРЭЭ:

Нийслэлийн харьяа ӨЭМТ-ийн удирдлага болон чанар хариуцсан мэргэжилтэн нийт 134 хүн хамрагдана.

## СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ:

- Лекц
- Бүлгийн ажил
- Харилцан ярилцах
- Дадлага ажил
- Туршлагаа хуваалцах

## СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн сургалтын танхимд зохион байгуулагдана.

**СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ХУГАЦАА:**

- 2017 оны 12 сарын 12-13-ны өдрүүдэд Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх, Багануур дүүргийн 64 өрхийн эмнэлгийн чанар хариуцсан их эмч нар
- 2017 оны 12 сарын 14-15-ны өдрүүдэд Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянгол дүүргийн 70 өрхийн эмнэлгийн чанар хариуцсан их эмч нар

**СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ:** 1 багц цаг

**СУРГАЛТ УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН:**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Чанар, магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтнүүд сургалтыг удирдан явуулна.

**ХҮРЭХ ҮР ДҮН:**

Чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах, асуудлыг тодорхойлж, хэрхэн сайжруулахыг олж харах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эмнэлгийн алдаа, эрсдлийг тодорхойлох, үнэлэх мэдлэг ур чадварыг сайжруулах

**СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН:**

- Компютер, проектор
- Бүлгийн ажлын цаас, маркер
- Шалгах хуудас, шалгуур үзүүлэлт

# Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага сургалтын хөтөлбөр

| Хугацаа | Сэдэв | Хариуцагч |
|---|---|---|
| **1 өдөр /2017.12.14/** | | |
| 10:00-10:15 | Сургалтанд оролцогчдыг бүртгэх | Зохион байгуулагчид |
| | Нээлт | ЭМХТ-ийн Ерөнхий захирал Б.Нарантуяа |
| 10:15-10:25 | Оролцогсдын мэдлэгийн сорил | Зохион байгуулагчид |
| 10:25-10:45 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр (2018-2022) | Я.Амаржаргал, ЭМЯ-ны ЭТГ-ын ахлах мэргэжилтэн |
| | 10:45-11:00 Цайны завсарлага | |
| 11:00-11:30 | Чанар сайжруулах арга хэрэгслүүд | Э.Тунгалаг, ЗӨСҮТ-ийн Чанарын албаны дарга |
| 11:30-12:30 | Бүлгийн ажил, хэлэлцүүлэг: "Чанар сайжруулах арга хэрэгслүүдийг практикт хэрэглэх нь" | Э.Тунгалаг, ЗӨСҮТ-ийн Чанарын албаны дарга |
| | **12:30-13:30 Үдийн завсарлага** | |
| 13:30-14:00 | Чанарын хяналт /өөрийн болон гадаад үнэлгээ/ | Н.Цэндмаа, ЭМХТ-ийн ЧМИА-ны мэргэжилтэн |
| 14:00-15:30 | Бүлгийн ажил, хэлэлцүүлэг: Чанарын хяналт | Н.Цэндмаа, ЭМХТ-ийн ЧМИА-ны мэргэжилтэн |
| | 15:30-15:40 Цайны завсарлага | |
| 15:40-16:00 | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны шинэчлэгдсэн стандартын танилцуулга | Н.Цэндмаа, ЭМХТ-ийн ЧМИА-ны мэргэжилтэн |
| **2 өдөр /2017.12.15/** | | |
| 10:00-10:30 | Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлага | Н.Ариунболд, НЯТТ-ийн дэд дэрга |
| | 10:30-10:45 Цайны завсарлага | |
| 10:45-12:30 | Бүлгийн ажил, хэлэлцүүлэг: Өөрийн байгууллагын эрсдэлийг тодорхойлох нь | Н.Ариунболд, НЯТТ-ийн дэд дэрга |
| | **12:30-13:30 Үдийн завсарлага** | |
| 13:30-14:00 | Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх | Г.Баясгалан, УХТЭ-ийн захирал |
| 14:00-14:15 | Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх?(видео) | Г.Баясгалан, УХТЭ-ийн захирал |
| 14:15-15:00 | Алдаа зөрчил гэж юу вэ? | А.Оюунчимэг, ЭХЭМҮТ-ийн Чанарын албаны дарга |
| | 15:00-15:20 Цайны завсарлага | |
| 15:20-15:40 | Бүлгийн ажил, хэлэлцүүлэг :Алдаа зөрчлийг бүртгэх | А.Оюунчимэг, ЭХЭМҮТ-ийн Чанарын албаны дарга |
| 15:40-16:00 | Эрүүл мэндийн байгууллагуудын чанарын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ерөнхий мэдээлэл ба чанарын удирдлагын сургалтын хэрэгцээ тогтоох судалгааны танилцуулга | П.Мидриймаа, ЭМХТ-ийн ЧМИА-ны мэргэжилтэн |
| 16:00-16:10 | Хаалтын үйл ажиллагаа<br>Гэрчилгээ гардуулах | Зохион байгуулагчид |

*Эрүүл мэндийн хөгжлийн төвийн*
*Ерөнхий захирлын 2017 оны ..12.. сарын ..05.. өдрийн*
*А/....219 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт*

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА" СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Зардлын зүйл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Зардлын жишиг | Нийт зардал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багшийн цалин | хүн | 24 | 20,000 | 480,000 |
| 2 | Бичиг хэргийн зардал | хүн | 134 | 2,000 | 268,000 |
| 3 | Оролцогчдын цайны зардал | хүн/өдөр | 134/8 | 2,000 | 2,144,000 |
| 4 | Гэрчилгээ хэвлүүлэх | ширхэг | 134 | 1,000 | 134,000 |
| 5 | Сургалтын материал хувилах | хүн/нүүр | 134/50 | 50 | 335,000 |
| 6 | Сургалтын бусад зардал /Анонс, утасны карт, бичгийн цаас, самбарын үзэг, флипчартын цаас, бичгийн хавчаар гэх мэт/ | | | | 530,000 |
| | НИЙТ ДҮН | | | | 3,891,000 |

Хянасан: Д.Гантуяа

Боловсруулсан: Х.Ганцэцэг